



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 491

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 9,594,300.00 /есөн сая таван зуун ерэн дөрвөн мянга гурван зуун/ төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Я.Амаржаргал, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн гүйцэтгэх захирал Ц.Уранчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

D.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн нөмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн
19/ Дугаар тогтоолын хавсралт



Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашини жагсаалт

Д/Н	Автомашины марк, улсын дугаар, араб	ҮННЛТ, КМ (Mile) автомашинчесч, амнитатара оцоо ох	Балансын үнэ (төгрөг)	Хүримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Делика MMC, 55-89 УБЯ, арал №РА4УN-0300476	1997/ 2006	15231	9,594,300.00	9,594,300.00	0	500,000.00
	Нийт дүн			9,594,300.00 /есөн сая таван зуун ерэн дервөн мянга гурван зүйн/	9,594,300.00 /есөн сая таван зуун ерэн дервөн мянга гурван зүйн/	0	500,000.00 /таван зуун мянган/